



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10 нэрийн, нийт 220,600,397.26 (хоёр зуун хорин сая зургаан зуун мянга гурван зуун ерэн долоон төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагын (компанийн) дансанд төвлөрүүлэх;

2.3. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001260

9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
19.6 дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Фургон- /УАЗ-22069/, 45-98 БӨА	2015/2015	25,695,454.54	25,695,454.54	0	0	5,500,000.00
2	Фургон- /УАЗ-22069/, 22-98 ГАУ	2014/2014	29,600,000.00	29,600,000.00	0	0	5,500,000.00
3	Фургон- /УАЗ-22069/, 12-36 ДГО	2014/2014	29,600,000.00	29,600,000.00	0	0	5,500,000.00
4	Фургон- /УАЗ-22069/, 35-01 ХЭУ	2013/2013	22,500,000.00	22,500,000.00	0	0	5,500,000.00
5	Фургон- /УАЗ-22069/ 96-64УБВ, 70422556	2007/2007	12,272,727.28	12,272,727.28	0	0	3,500,000.00
6	Фургон /УАЗ-22069 68-32 УБД/, 0474047	1998/1999	6,168,690.00	6,168,690.00	0	0	3,000,000.00
7	Марк 2 59-89 УБӨ, GX1106007023	2001/2007	15,313,414.60	15,313,414.60	0	0	3,500,000.00
8	Ниссан экстрейл /18-42 УБӨ/	2007/2007	32,177,383.57	32,177,383.57	0	0	7,000,000.00
9	УАЗ фургон /96-63 УБВ/	2006/2007	12,272,727.27	12,272,727.27	0	0	3,500,000.00
10	Эксковатор 98-83УБ	2001/2013	35,000,000.00	35,000,000.00	0	0	10,500,000.00
Нийт дүн			220,600,397.26 (хоёр зуун хорин сая зургаан зуун мянга гурван зуун ерэн долоон төгрөг хорин зургаан мөнгө)	220,600,397.26 (хоёр зуун хорин сая зургаан зуун мянга гурван зуун ерэн долоон төгрөг хорин зургаан мөнгө)	-	-	53,000,000.00 (тавин гурван сая)